



БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТӨХК Ш. БАЯНМОНХ



БАТЛАВ:  
СТАНДАРТ НЕТВОРК ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Х.ПҮРӨВЖАЛ

**ГАЛЫН ДОХИОЛОЛЫН СИСТЕМИЙГ ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ,  
ГАЛААС ХАМГААЛАХ СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 43/2022

2022 оны 04-р сарын 15 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх /цаашид захиалагч гэх/нөгөө талаас Стандарт нетворк ХХК-ийн захирал Х.Пүрэвжал /цаашид гүйцэтгэгч гэх/хамтад нь /цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2 дахь заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

1.1 Гэрээний зорилго нь “Галын дохиололын системийн шинэчлэн засварлах, галаас хамгаалах сэлбэг хэрэгсэл нийлүүлэх” хийх ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг хангаж хулээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хэлбэр, хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хулээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Гэрээний нөхцөл, ерөнхий зүйл**

2.1 Галын дохиололын системийн шинэчлэн засварлах ажлыг 2022 оны 04 дугаар сарын 18-аас эхлэн 08-р сарын 15-нд дуустал хийж гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол нарядд нээгдсэн өдрөөр тооцож болно.

2.2 Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж /эсвэл сунгахгүй/ болно.

**Гурав. Төлбөр тооцоо**

3.1 Гэрээт ажлын үнэ нь 35,043,290/гучин таван сая дөчин гурван мянга хоёр зуун ер/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ нь НӨАТ багтсан мөн хуулийн 28.6-р зүйлд зааснаар татвар даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.

3.2 Галаас хамгаалах сэлбэг хэрэгсэл нийлүүлэх 19,465,600 /арван есөн сая дөрвөн зуун жаран таван мянга зургаан зуу/-н төгрөгийн барааг нийлүүлснээс хойш нэхэмжлэлийн дагуу 90 хоногийн дотор багтаан төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны 450031290 тоот дансанд шилжүүлнэ.

3.3 Гэрээт ажлын төлбөр тооцоог 15,577,690/арван таван сая таван зуун далан долоон мянга зургаан зуун ер/-н төгрөгийн ажлыг хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 90 хоногийн дотор багтаан бодит гүйцэтгэлээр гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 450031290 тоот дансанд шилжүүлнэ.

#### **Дөрөв: Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

4.1 Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан эзлэхүүний дагуу, тендерт шалгарсан үнэд багтаан батлагдсан графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэгчийг ажлын чанараас шалтгаалан гэмтэл гарсан нь актаар батлагдвал үнэ төлбөргүй дахин хийж гүйцэтгэж хохирлыг барагдуулна.

4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлэгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсоно.

4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.

Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

Гэрээ дүгнэсэн акт	4хувь
Хуучин сэлбэг тушаасан баримт	4хувь
Тухайн тоноглолтой холбоотой бусад акт баримтууд	4хувь
Засварын өмнөх ба дараах ажлуудыг фото зургаар баримтжуулан хавсаргах	4хувь

4.5 Ажил гүйцэтгэхдээ шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.

4.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусад шилжүүлэхгүй байх үүрэгтэй

4.7 Ажлыг гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.

#### **Тав: Захиалагчийн эрх үүрэг**

5.1 ХАБ, ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.

5.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна

5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.

### **Зургаа: Талуудын хүлээх үүрэг хариуцлага**

6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10 % иас хэтрэхгүй байна.

6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -ийн алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

6.3 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэсэн ажлын чанар, техникийн гологдол, эвдрэл гарвал захиалагч нь мэдсэн буюу мэдэх боломжит өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 5 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засч хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.4 Компани дотоод журам ,ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.

6.5 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

6.6 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, төсөвт ажилбар, тээвэр механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн зөрүү гарсан тухай бүр хоёр тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.

6.7 Захиалагчийг төлөөлж засварын ажилтай холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн ХАБЭА инженер Л.Цэцэгсүрэн хариуцан ажиллана. Утас-88113409

6.8 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Стандарт нетворк” ХХК-ийн инженер Т.Сумьяасүрэн хариуцан ажиллана. Утас-88052055

### **Долоо: Давагдашгүй хүчин зүйл**

7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт

импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагчаар цуцлан

7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгднө.

#### **Найм: Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах**

8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй

8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бараа нийлүүлэх хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлаж гүйцэтгэлийн баталгааг буцаан олгогүй.

#### **ЕС : Бусад зүйл**

9.1 Энэ хүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж , талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.

9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.

9.4 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

9.5 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
АЖ АХУЙ ХАНГАМЖ ЭРХЭЛСЭН ДЭД  
ЗАХИРАЛ Б.УРТНАСАН

Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг:

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П.ЗОРИГОО

Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ

Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН Г.БАЯРЧИМЭГ

Гарын үсэг:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар

хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1

Утасны дугаар: 77111251

РД: 6021646

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

СТАНДАРТ НЕТВОРК ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ПУРЭВЖАЛ

Гарын үсэг:



СТАНДАРТ НЕТВОРК ХХК

ЗАХИРАЛ Х.ПУРЭВЖАЛ

Гарын үсэг: *Х.Пурэвжал*

ХХК

ИУТТ5308

1119277240 6388906

Хаяг: БЗД 4-р хороо 15 хороолол хилчин

25 тоот

Утас: 75778313


РД: 6388906

тоот гэрээний хавсралт

**Галын сэлбэг хэрэгсэл нийлүүлэх үнийн санал**

Барааны нэр терөл	Тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	НӨАТ	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7
Галын жоотуутай сух	Модон иштэй	5	38,500	192,500	19,250	211,750
Хүрз	1.5м урт, модон иштэй, 3кг	5	15,400	77,000	7,700	84,700
Галын дэгээ	Төмөр, 100см	5	25,300	126,500	12,650	139,150
Галын хөнжил	1.5м*1.5м	5	36,300	181,500	18,150	199,650
Царил	Төмөр, 100см	5	19,800	99,000	9,900	108,900
Галын хувин	8л багтаамжтай	5	15,400	77,000	7,700	84,700
Жоотуу	Модон иштэй, төмөр жоотуу	5	25,300	126,500	12,650	139,150
Галын сарай	Урт: 1.5м, өргөн нь 1.2м, өндөр 1.70м	3	869,000	2,607,000	260,700	2,867,700
Галын лоом	1.5м урт, төмөр	5	25,300	126,500	12,650	139,150
Галын самбар, анхааруулах, хориглох тэмдэг	80x60 см хэмжэтэй самбар болон бусад тэмдэглэгээ	15	47,500	712,500	71,250	783,750
Галын шиддэг хор	AFO бөөрөнхий, Хамгаалах талбай: 2- 3м3	25	44,000	1,100,000	110,000	1,210,000
Галын хор цэнэглүүлэх	Бүх төрлийн нунтаг /ABC, BC/	400	4,500	1,800,000	180,000	1,980,000
Галын стенд	Ажлын даралт н 1.0 МПа, Оролт DN 125мм, Гаралт 80мм, Өндөр 1080мм	2	1,980,000	3,960,000	396,000	4,356,000
Галын стендны шланг /ф80/	Ажлын даралт нь 1.6МПа, 20м*DN80мм, MNS:2014 стандартын шаардлага хангасан	2	330,000	660,000	66,000	726,000
Гар станц	Baofeng m4	30	195,000	5,850,000	585,000	6,435,000
Нийт дүн						<b>19,465,600</b>

Амгалан дулааны станц ТӨХК -ийн

ХАБЭА инженер  Л.Цэцэгсүрэн

Стандарт Нетворк ХХК -ийн

Инженер  Т.Сумьяасүрэн

Галын дохиоллын системийг шинэчлэн засварлах ажил гүйцэтгэх үнийн санал

Барааны нэр төрөл	Тодорхойлолт	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	НӨАТ	Бүгд дүн
Галын дохиоллын системийг шинэчилэн засварлах	1. Галын дохиоллын системд үзлэг хийж гэмтэл тодорхойлох 2. Хуучин техөөрөмжүүдийг салгах 3.Шинэ техөөрөмжүүдийг сууринуулах, 4. Галын дохиоллын ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургалт орж, ашиглалтын заавар боловсруулж өгөх,5. Ажлын байрыг цэвэрлэж, засварын ажлыг хүлээж авах комисст хүлээлгэж өгөх 6. Засварын ажлын гүйцэтгэлийн акт болон холбогдох зураг, схемийг захиалагч талд хүлээлгэж өгөх	1	5,250,000	5,250,000	525,000	5,775,000
Гар мэдээлэгч	TC910A1056D	8	356,400	2,851,200	285,120	3,136,320
Оролт, гаралтын модуль	TC909A1059	7	392,400	2,746,800	274,680	3,021,480
Оролтын модуль	HONEY WELL 887 EOL	10	270,000	2,700,000	270,000	2,970,000
Термокабелийн төгсгөлийн хайрцаг	HONEY WELL 887 EOL	2	263,568	527,136	52,714	579,850
Термокабелийн дундын хайрцаг	HONEY WELL JTW-LD-85-8687	3	28,800	86,400	8,640	95,040
Нийт үнэ						15,577,690
Тендерийн нийт үнэ						35,043,290

Амгалан дулааны станц ТӨХК -ийн

ХАБЭА инженер  Л.Цэцэгсүрэн

Стандарт Нетворк ХХК -ийн

Инженер  Т.Сумъяасүрэн